

ЗӨВЛӨМЖ:

1. ИТГЭМЖЛЭЛИЙН ЗАГВАРУУДЫГ САЙТАР УНШИЖ, ЗӨВХӨН ӨӨРТ ШААРДЛАГАТАЙ БУЮУ МОНГОЛД БАЙГАА ТӨЛӨӨЛӨГЧИД ОЛГОХ БҮРЭН ЭРХЭЭ СОНГОНО УУ.
2. **УЛААНААР** ТЭМДЭГЛЭСЭН ХЭСГҮҮД ДЭЭР ӨӨРИЙН МЭДЭЭЛЛИЙГ НЯГТАЛЖ ОРУУЛНА УУ.

ШИНЭЭР ТӨРСӨН ХҮҮХДИЙН ГАДААД ПАСПОРТ ЗАХИАЛАХ, ХҮҮХДИЙН МӨНГӨ, ЦАЛИНТАЙ ЭЭЖ

____ Бидний/миний ____ охин/хүү ____ Овог нэр ____ /РД: ЦФ ____ /
шинээр энгийн цахим гадаад паспорт захиалахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, лавлагаа тодорхойлолт хүсэх, хүлээн авах, нотариатаар баталгаажуулах, хүсэлт өргөдөл гаргах, маягт бөглөх, бичиг баримт хүлээлгэн өгөх, биднийг төлөөлөн гарын үсэг зурах, төлбөр тооцоо хийх, энгийн цахим гадаад паспорт захиалах, энгийн цахим гадаад паспорт хүлээн авах, гарын үсэг зурах
мөн хүүхдийн мөнгө авах болон цалинтай ээж хөтөлбөрт хамрагдахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, лавлагаа тодорхойлолт хүсэх, нотариатаар баталгаажуулах, бичиг баримт хүлээлгэн өгөх, хүсэлт өргөдөл гаргах, маягт бөглөх, биднийг төлөөлөн гарын үсэг зурах, хариу хүлээн авах, цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд олгогдох мөнгийг ____ Овог нэр ____ Банкны нэр ____ банк дахь ____ дансны дугаар ____ тоот данс руу шилжүүлэх хүсэлт гаргах, хүүхдийн мөнгө хүлээн авах дансыг ____ Банкны нэр ____ банканд шинээр нээлгэх, шинэ харилцагч бүртгүүлэх, харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах, хүүхдийн нэрийн дансанд орох мөнгөн хөрөнгийг хүүхдийн хадгаламжийн дансанд автоматаар татагддаг үйлчилгээнд бүртгүүлэх, үүнтэй холбогдуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ болон мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулж гарын үсэг зурах, хүсэлт өргөдөл гаргах, мастер гэрээ байгуулах, биднийг төлөөлөн гарын үсэг зурах, шинээр нээлгэсэн дансны хамтран эзэмшигчээр ____ аав/ээж ____ болох ____ Овог нэр ____ бүртгүүлэх, шинээр нээсэн дансыг ____ Овог нэр ____ Банкны нэр ____ банк дахь ____ дансны дугаар ____ тоот данстай холбуулах, харилцагчийн мэдээлэл шинэчлэх, бичиг баримт хүлээлгэн өгөх, холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах

ХҮҮХЭД ВИЗЭНД ОРУУЛАХ

Бидний/миний хүү/охин ____ Овог нэр ____ /РД: _____, паспортын дугаар: _____ /-ыг Унгар Улсад _____ зорилгоор виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, лавлагаа тодорхойлолт хүсэх, хүлээн авах, нотариатаар баталгаажуулах, баталгаат орчуулга хийлгэх, VFS Global виз

мэдүүлгийн төвд виз мэдүүлэх, бичиг баримт хүлээлгэн өгөх, өргөдөл хүсэлт гаргах, маягт бөглөх, төлбөр тооцоо хийх, шаардлагатай тохиолдолд ярилцлагад хамт орох, виз мэдүүлгийн хариу болон паспорт хүлээн авах

ХҮҮХЭД ХИЛИЙН ЧАНАД РУУ АВЧ ЯВАХ/ХИЛИЙН ЧАНАДААС АВЧРАХ

____ Бидний/миний ____ охин/хүү ____ Овог нэр ____ /РД: ЩФ _____, паспортн дугаар: _____/-ыг Монгол Улсаас ____ Улсын нэр _____ Улс руу ____ зорилго: суралцах, аялах, эмчилгээнд орох гэх мэт _____ зорилгоор явахад нь болон Монгол Улс руу буцаж ирэхэд нь асран хамгаалж, харгалзан дэмжиж авч зорчих, хил гаалиар хариуцан авч нэвтрэх, аяллын хугацаанд амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, холбогдох бичиг баримтад намайг төлөөлөн гарын үсэг зурах

ХАЯГИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН ХИЙХ ТУХАЙ

/тухайн үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч нь харьяа сум, хороонд очиж хийлгэнэ/

/хүүхэд бол хүүхдийн овог, нэр, регистрийн дугаарыг заавал бичнэ/

____ Хаяг: Нийслэл/аймаг, дүүрэг/сум, хороо/баг, дэлгэрэнгүй хаяг ____ тоот хаягт бүртгүүлэх, хаягийн шилжилт хөдөлгөөн хийх, шинэ хаягт бүртгүүлэх, хороо, дүүрэгт төлөөлөх, иргэний оршин суугаа хаягийн шилжилт хөдөлгөөн хийх өргөдөл, хүсэлт бичиж өгөх, маягт бөглөх, намайг төлөөлөн гарын үсэг зурах, шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлж өгөх, хаягийн шинэчилсэн бүртгэлийг улсын бүртгэлийн мэдээллийн санд орсон эсэхийг шалгах, холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах

ХҮҮХДИЙГ СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГТ БҮРТГҮҮЛЭХ, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ, АСРАН ХАМГААЛАХ

____ Бидний/миний ____ охин/хүү ____ Овог нэр ____ /РД: _____/-ыг боловсролын байгууллагад бүртгүүлэх, **ерөнхий боловсролын сургууль/сургуулийн өмнөх боловсрол** -ын байгууллагад бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, холбогдох лавлагаа тодорхойлолт хүсэх, хүлээн авах, бичиг баримт нотариатаар баталгаажуулах, бичиг баримт хүлээлгэн өгөх, холбогдох хүсэлт өргөдөл гаргах, маягт бөглөх, төлөөлөн гарын үсэг зурах, эмнэлгийн байгууллагаас үйлчилгээ авах, шаардлагатай шинжилгээ, эмчилгээ хийлгэх, лавлагаа, тодорхойлолт, шинжилгээний хариу хүлээн авах, боловсролын байгууллагад хүлээлгэн өгөх, хүүхдийн боловсрол эзэмшихтэй холбоотой бүхий л асуудалд төлөөлөн оролцох, сургуулийн захиргаа, багш сурган хүмүүжүүлэгч нартай уулзаж холбогдох мэдээ, мэдээлэл авах, холбогдох хүсэлт өргөдөл, гомдол гаргах, төлөөлөн гарын үсэг зурах, хүүхдийн эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлын хангахад шаардлагатай бүхий л үйлдэл хийх

БИЧИГ БАРИМТ ЗАХИАЛАХ /ӨӨРТӨӨ/

/Хэрэв хүүхдэд бол хүүхдийн овог, нэр, регистрийн дугаарыг заавал бичнэ/

_____ **СОНГОЖ БИЧНЭ ҮҮ:** иргэний цахим үнэмлэх/энгийн цахим гадаад паспорт/жолооны үнэмлэх _____ захиалахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, лавлагаа тодорхойлолт хүсэх, хүлээн авах, нотариатаар баталгаажуулах, хүсэлт өргөдөл гаргах, маягт бөглөх, бичиг баримт хүлээлгэн өгөх, биднийг төлөөлөн гарын үсэг зурах, төлбөр тооцоо хийх, _____ **СОНГОЖ БИЧНЭ ҮҮ:** иргэний цахим үнэмлэх/ энгийн цахим гадаад паспорт/жолооны үнэмлэх _____ захиалах, хүлээн авах, холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах

ИНТЕРНЕТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ СЭРГЭЭХ, ЭРХ АВАХ

/Банкны нэр, дансны дугаараа заавал бичнэ/

_____ **Банкны нэр** _____ банк дахь _____ **дансны дугаар** _____ тоот дансны харилцагчийн мэдээлэл шинэчлэх, харилцагчийн мэдээлэлд _____ **утасны дугаар** _____ утасны дугаар болон _____ **имэйл хаяг** _____ имэйл хаягийг бүртгүүлэх, тус имэйл хаяг болон утасны дугаарыг ашиглан _____ **Банкны нэр** _____ банкны аппликейшн болон интернет банкны эрх сэргээх, блок гаргах, нууц дугаар хүлээн авах, нууц дугаар сэргээх, солих, холбогдох хүсэлт өргөдөл гаргах, маягт бөглөх, намайг төлөөлөн гарын үсэг зурах

ТЭТГЭВЭР ТОГТООХОД ШААРДЛАГАТАЙ БИЧИГ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ, ХҮСЭЛТ ӨРГӨДӨЛ ГАРГАХ

тэтгэвэр тогтооход шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх, Нийгмийн даатгалын газар, холбогдох харьяа дүүрэг/аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Хөдөлмөр халамжийн хэлтсээс лавлагаа тодорхойлолт авах хүсэлт гаргах, хүлээн авах, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Архивын ерөнхий газар, Үндэсний төв архив, Нийслэлийн болон дүүргийн архиваас ажилласан жилийн лавлагаа авах хүсэлт гаргах, хүлээн авах, хөдөлмөрийн дэвтэр дээрх тушаалуудын хуулбар, лавлагаа тодорхойлолт хүсэх, хүлээн авах, /**цэргийн алба хаасан бол/ Батлан хамгаалах яамны архив болон холбогдох байгууллагаас цэргийн алба хаасан тухай лавлагаа тодорхойлолт хүсэх, хүлээн авах**, нийгмийн даатгал, шимтгэл төлж байсан тухай лавлагаа тодорхойлолтыг Нийгмийн даатгалын газрын архиваас болон холбогдох байгууллагаас хүсэх, хүлээн авах, хилийн чанадад нийгмийн даатгал, татвар төлж байсан тухай лавлагаа тодорхойлолт хүсэх, хүлээн авах, нотариатаар баталгаажуулах, холбогдох дүүрэг, аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст тэтгэвэр тогтоолгох бичиг баримт хүлээлгэн өгөх, намайг төлөөлөн хүсэлт өргөдөл гаргах, маягт бөглөх, холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах, тэтгэврийн дэвтэр нээлгэх, хүлээн авах, гарын үсэг зурах,

БАНКАНД ТЭТГЭВРИЙН ДАНС НЭЭЛГЭХ

___**Банкны нэр**___ банканд миний нэр дээр тэтгэврийн данс нээлгэх, тэтгэврийн данс нээлгэхэд шаардлагатай бичиг баримт бүрдүүлэн өгөх, шинэ харилцагч бүртгүүлэх, харилцагчийн мэдээлэл шинэчлэх, намайг төлөөлөн холбогдох хүсэлт өргөдөл гаргах, маягт бөглөх, гарын үсэг зурах, харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах, нэрийн дансанд орох мөнгөн хөрөнгийг тэтгэврийн дансанд автоматаар татагддаг үйлчилгээнд бүртгүүлэх, үүнтэй холбогдуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх гэрээ болон мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулж гарын үсэг зурах